



НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ  
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХЭД

## АРДЧИЛСАН НАМ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо  
Жигжиджавын гудамж-3, Их Эзэн Чингис хааны талбай,  
Бодь цамхаг 10 давхарт. Утас: (976) 98061206  
E-mail: info@demparty.mn https://www.demparty.mn

2020.12.15 № 01/256

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Нэхэмжлэл гаргах тухай

#### НЭХЭМЖЛЭГЧ: Ардчилсан нам

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1 хороо,  
Жигжиджавын гудамж 3, Эх эзэн Чингис Хааны талбай,  
Бодь Цамхаг, 10 давхарт,

Утас: 85825004

#### ХАРИУЦАГЧ: Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газар

Хаяг: 14190 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 7-р хороо, Их тойруу  
УБЕГ-ын байр

Утас: 11320502

**Нэхэмжлэлийн шаардлага:** Сонсох ажиллагаанд оролцуулахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, иргэн С.Эрдэнийн гаргасан Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгуулах тухай хүсэлт шийдвэрлэх ажиллагаанд Ардчилсан намыг оролцуулж тайлбар, санал гаргах боломж олгохыг даалгах тухай.

**Нэхэмжлэлийн үндэслэл:** Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газар нь иргэн С.Эрдэнийн гаргасан Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгуулах тухай өргөдлийг хянан шийдвэрлэж байна.

Ардчилсан нам нь 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг ..... оноос хойш өнөөдрийг хүртэл хэрэглэж байгаа бөгөөд уг тамгыг хүчингүй болгож, дахин шинээр хийлгэх ямар ч шаардлага байхгүй болно. Өөрөөр хэлбэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт зааснаар тамга, тэмдгийн хяналтын дугаарыг дахин авах, шинээр хийлгэх үндэслэл бий болоогүй байна.

Ардчилсан намын Үндсэн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-т "АН нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ. Нам нь өөрийн бэлгэдэл, туг, тамга, тэмдэг, нэг загварын албан хуудастай байна.", 2.5-д "Намын нэр, бэлгэдэл, туг, албан хуудас, тамга,

тэмдгийг хэрэглэх, хадгалах асуудлыг зохицуулах журамтай байна.", 5 дугаар зүйлийн 5.13.12.27. УБХ нь намын Үндсэн дүрэмд нийцүүлэн дараах дүрмүүдийг баталж, мөрдүүлнэ. Үүнд: 5.13.12.27.1. Намын бэлэгдэл, туг, албан хуудас, тамга, тэмдэг хэрэглэх, хадгалах тухай;" гэж тус тус заасан.

1117237845 хяналтын дугаар бүхий Ардчилсан намын тамга нь дээрх дүрэм, журмын дагуу хэвийн хадгалагдан хэрэглэгдэж байна.

Мөн Үндсэн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн 8.5.2.2-т зааснаар намын тамга нь намын өмчлөлд бүртгэлтэй оюуны өмчлөлийн зүйлст хамаардаг хөрөнгө юм. Тиймээс, Ардчилсан намын одоо ашиглаж буй 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгох нь тус намын өмч хөрөнгийг устгаж байгаатай адил юм.

Гэтэл УБЕГ-ын Хяналт шалгалтын газар нь Ардчилсан намын өмч хөрөнгийг устгах шийдвэр гаргах ажиллагаандаа Ардчилсан намыг оролцуулж, тайлбар, санал гаргах боломж олгох байгаа нь хууль бус гэж үзэж байна.

УБЕГ-ын Хяналт шалгалтын газар нь Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгуулах тухай иргэн С.Эрдэнийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдээр Ардчилсан намыг бус, харин Ардчилсан намын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Тувааныг албан тушаалтных нь хувиар бус иргэнийх нь хувиар татан оролцуулж тайлбар авах ажиллагаа явуулж байгаа нь хуульд нийцэхгүй байна.

Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйл (Оролцогчийг сонсох)-ийн 26.1. Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно., 26.2. Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ., 27 дугаар зүйлийн 27.1. Захиргааны шийдвэр гаргах захиргааны байгууллага эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлно., 27.2. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдэд дараах байдлаар хүргүүлнэ: 27.2.1. хорь буюу түүнээс доош тооны этгээдийг сонсохоор бол мэдэгдлийг этгээд тус бүрд шууд хүргүүлэх; гэж тус тус заасан.

Ардчилсан намын тамгыг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэхэд Ардчилсан намын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа нь илэрхий байхад УБЕГ-ын Хяналт шалгалтын газар ямар үндэслэлээр Ардчилсан намын байр суурийг асууж тодруулахаас зайлсхийж, сонсох ажиллагаанд Ардчилсан намыг бус, иргэн Ц.Тувааныг татан оролцуулж тайлбар, санал авч байгаа нь ойлгомжгүй байна.

Иймд иргэн С.Эрдэнийн гаргасан Ардчилсан намын 1117237845 хяналтын дугаар бүхий тамгыг хүчингүй болгуулах тухай хүсэлт шийдвэрлэх ажиллагаанд Ардчилсан намыг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдээр тодорхойлж, сонсох ажиллагаанд оролцуулахгүй байгаа УБЕГ-ын Хяналт шалгалтын газрын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, уг


ажиллагаанд Ардчилсан намыг оролцуулж, тайлбар, санал гаргах боломж олгохыг хариуцагчид даалгаж өгнө үү.

Хавсаргасан баримтууд:

1. Нэхэмжлэл 1 хувь
2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
3. Ардчилсан намын гэрчилгээ, дүрэм
4. Улсын дээд шүүхийн 2020.12.22-ны өдрийн 5/5051 тоот албан бичиг
5. Ардчилсан намын Үндэсний бодлогын хорооны хурлын 2020.07.24-ний өдрийн 16/06 дугаар "Ардчилсан намын даргын үүргийг түр шилжүүлэх тухай" тогтоол
6. УБЕГ-ын Хяналт шалгалтын газраас иргэн Ц.Туваанд ирүүлсэн 2020.12.21-ний өдрийн 8/10759 тоот "Тайлбар санал ирүүлэх тухай" сонсох ажиллагааны мэдэгдэл
7. Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлт

Нэхэмжлэл гаргасан:

НАМЫН ДАРГЫН ҮҮРЭГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ТУВААН